

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН ТҮҮНИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА



Б.БАТБОЛД

Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр
гүйцэтгэлийн сургуулийн захирал, хурандаа

Хураангуй: Дэлхийн дийлэнх орнууд ард иргэдийнхээ боловсролын түвшинд ихээр анхаарч байна. Үүнийг даган тус чиг үүргийг хэрэгжүүлдэг боловсролын байгууллагын бие даасан байдлыг бэхжүүлэх, эрх зүйн орчинг бий болгох шаардлага бий болсон гэж үзэж байна. Илтгэлд Дотоод хэргийн их сургуулийн эрх зүйн орчны асуудлуудыг судлан авч үзсэн.

Abstract: The vast majority of countries around the world are paying close attention to their educational level. It is imperative to strengthen the independence of educational institutions that implement these functions and create a legal environment. The article is devoted to the analysis of issues legal sphere of University of internal affairs of Mongolia.

Түлхүүр үг: Дотоод хэргийн их сургууль, эрх зүйн байдал, хөтөлбөр, сургалтын байгууллага.

Keywords: University of internal affairs of Mongolia, legal status, training programs, educational institution.

Өнөө үед дэлхийн улс орнууд ард иргэдийнхээ боловсролд гол анхаарлаа хандуулж, боловсролын салбарт оруулсан хөрөнгө оруулалтаар тухайн улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдал, хөгжил, оршин тогтнох байдал хэмжигдэж улс орныхоо хөгжлийн чиг хандлагыг тодорхойлж иржээ. Тусгаар улсуудын ард иргэд хэдий чинээ боловсрол, мэдлэгтээ анхаарснаар тухайн улс орны оршин тогтнох үндэс баталгаатай байхыг хүлээн зөвшөөрсөн байдаг.

Хүнийг сургах гэдэг нь эртний Педагогик (pedagogy) буюу сургалт гэдэг нь грек гаралтай үг бөгөөд “пайдос” – хүүхэд, “аго” – дагуулж явах,

шууд утгаараа хүүхдийг дагуулж явах гэсэн утгатай¹. Эртний Грекд эзнийхээ хүүхдийг сургуульруу дагуулж явж байгаа боолыг ийнхүү нэрлэдэг байсан бөгөөд, сургуульд нь өөр нэг боол-эрдэмтэн хичээл заадаг байсан байна. Цаг хугацаа өнгөрсөөр энэхүү ойлголт нь “хүүхдийг амьдралд хөтлөх” болж хувьсан өөрчлөгджээ. Харин XIX зууны сүүл үе XX зууны эхэн үеэс сургалт нь зөвхөн хүүхдэд гэлтгүй насанд хүрсэн хүнд ч хэрэгтэйг тодорхойлсон олон онол урсгалүүсэн хөгжиж ирсэн.

Сургалтын үйл ажиллагааны түүхэн хөгжлийг авч үзвэл анхны сургуулиуд Эртний Египет, Грек, Ромд байгуулагдаж, Александрийскийн их сургууль нэртэйгээр манай эрний V зуунд хамгийн анхны их сургууль байгуулж, тухайн сургууль нь 13 лекцийн танхимтай, 5000 гаруй суралцагчдыг багтаах боломжтой байсныг гэрчилсэн олдворыг археологчид илрүүлжээ². Өнөөдрийг хүртэл үйл ажиллагаагаа явуулж байгаа эртний их сургуулийн талаар эрдэмтэд тодорхойлохдоо 859 онд Мароккод байгуулагдсан Каруаны их сургууль буюу зарим эх сурвалжаас энэ нь их сургууль бус исламын шашины төв байсан гэж ойлгож болохоор байдаг нь их сургуулийн үүсэл хөгжлийн түүх өнөөг хүртэл маргаантай хэвээр байгааг харуулж байна. Европ тивд анхны их сургуулиуд Италийн Болони хотод, 1200 онд Парисийн их сургууль, 1209 онд алдарт Кембрижийн их сургууль, 1348 онд Прагийн их сургууль, 1365 онд Чехийн их сургууль байгуулагдсан нь их сургууль улс орны хөгжлийн хандлагыг чиглүүлдэг онолын үүднээс авч үзвэл Европ тивийн хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулсан байдаг.

Монгол Улсад улс орны аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий хүний нөөцийг бэлтгэх гол түшиц бааз болсон манай Их сургуулийн түүхэн 85 жилийн ойонэ жил тохиож байна. Дотоод хэргийн их сургуулийн түүхэн хөгжил дэлхийн бусад орны их сургуулиудтай харьцуулбал ихээхэн залуу хэдий ч Монгол Улсад байгуулагдсан 2 дахь их сургууль гэдгээр нь нийт ажиллаж байгаа эрдэмтэн, багш, судлаач, сурч байгаа сонсогч суралцагчид, үе үеийн төгсөгчид маань төрөлх сургуулиараа бахархах нь зүйтэй юм.

Дотоод хэргийн их сургууль нь Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяанд үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд төрийн тусгай

¹ <https://dic.academic.ru/dic.nsf/ruwiki/19903>

² <http://vladhistory.com/istoriya-povavleniya-pervyx-shkol/>
<http://www.para.by/articles/text/samyi-pervyi-universitet>

чиг үүрэг бүхий мэргэшсэн алба хаагчдыг бэлтгэдэг боловсролын дээд байгууллага билээ.

Дотоод хэргийн их сургууль нь Монгол Улсын Засгийн газрын агентлагууд болох цагдаагийн байгууллага, хил хамгаалах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын болон шүүхийн шинжилгээний байгууллагуудын мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх зорилгоор Дээд боловсролын тухай хууль тогтоомжийн хүрээнд бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалт эрхлэхээс гадна судалгааны ажил зонхилсон лаборатори бүхий эрдэм шинжилгээ-сургалт-үйлдвэрлэлийн нэгдэл хэлбэртэй дээд боловсролын байгууллага бөгөөд шүүх эрх мэдлийн байгууллага, Прокурор, Архив, Улсын бүртгэл, Гадаадын иргэн, харьяат, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг, Гааль, Татвар, Нийгмийн даатгалын болон бусад төрийн байгууллага болон их дээд сургуулийн багш, судлаач, алба хаагчдыг магистр, докторын зэргийн сургалтад хамруулж, удирдах ажилтан болон судлаач мэргэжилтэн бэлтгэдгээрээ онцлогтой.

Сүүлийн жилүүдэд судлаачид их сургуулийн бие даасан байдлыг хангах зайлшгүй шаардлагатайг онцолж ирсэн бөгөөд тусгай хууль тогтоомжоор төрийн өмчийн их сургуулиудад нийтийн статус олгох, эрх тэгш хөгжих боломжоор хангах асуудлыг хөндсөөр байна.

Их сургуулийн эрх зүйн байдлыг тусгайлсан хуулиар зохицуулах боломж, жишиг байгаа эсэхийг судлан ОХУ-ын нийслэл Москва хот, Санкт-Петербург хотод байрлах нэр бүхий сургуулиуд болох М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн их сургууль, Санкт-Петербургийн их сургуулийн эрх зүйн байдал нь “М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн их сургууль болон Санкт-Петербургийн их сургуулийн” тухай Холбооны хуулиар зохицуулагддаг³. Тухайн хуулийн 1 дүгээр зүйлд энэхүү хуулиар Оросын Холбооны Улсын тэргүүлэх, сонгодог сургуулиуд болох М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн их сургууль, Санкт-Петербургийн их сургуулийн эрх зүйн байдлыг тодорхойлно гэж заасан байдаг.

Гэхдээ эдгээр их сургуулиуд нь 200-290 жилийн өмнө үүсгэн байгуулагдсан арвин туршлагатай өөрийн гэсэн судалгааны чиглэл тогтсон сургуулиуд болохыг онцлох нь зүйтэй.

Орчин үеийн сургуулиуд дунд ч мөн өөрийн гэсэн салбар хуультай сургуулиуд ч байдаг байна. Үүний тод жишээ нь Бүгд Найрамдах Казахстан

³ <https://rg.ru/2009/11/13/university-dok.html>

улс юм. Эрх зүйн тогтолцооны хувьд хурдацтай хөгжиж байгаа Бүгд Найрамдах Казахстан Улсын хувьд ч их сургуулийн эрх зүйн статусыг тодорхойлсон хуультай болох асуудалд анхаар “Назарбаевын их сургууль”-ийн эрх зүйн байдлыг тодорхойлсон Бүгд Найрамдах Казахстан Улсын “Назарбаев их сургууль, Назарбаев сэтгэн бодох сургууль, Назарбаев сан”-гийн тухай хуулийг 2010 онд баталсан байдаг⁴.

Үүнээс гадна эдийн засгийн хувьд хөгжингүй улсууд ч их сургуульд зориулсан тусгайлсан хуулиудтай байдаг жишиг байна. Жишээлбэл, Өмнөд Солонгос Улсад “Сөүлийн үндэсний их сургуулийн тухай” хууль (2014), “Улсаны шинжлэх ухаан, технологийн үндэсний институтын тухай” хууль (2013), Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад “Шпээрийн захиргааны шинжлэх ухааны их сургуулийн тухай” Райланд-Пфальц мужийн хууль (2010) юм.

Доктор, профессор Б.Бат-Эрдэнэ, Ж.Эрдэнэбулган нар дээрх орнууд их сургуульдаа тусгайлсан хуулийг баталсан гол үндэслэл нь тус орны сургуулиудын өвөрмөц байдал мөн бөгөөд их сургуулийн бие даасан байдлыг хангах, түүний өвөрмөц тогтолцоо нь, уламжлал, үнэт зүйл, профессор багш, тэргүүлэх эрдэмтдийн үйл ажиллагааг улс төр, нийгэм, эдийн засгийн сөрөг хүчин зүйлээс хамгаалах гол дархлаа болж байгаагаараа онцлог байна гэж тэмдэглэсэн байдаг⁵.

Монгол Улсад Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа 10 агентлаг, байгууллагууд үйл ажиллагаагаа явуулж байна. Дотоод хэргийн их сургуулийн хувьд байгууллагын статустай хэдий ч Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагуудын алба хаагчдыг бэлтгэж байгаа бөгөөд Дээд боловсролын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль гэх мэт салбар хууль тогтоомжуудыг удирдлага болгон ажиллаж байгаа юм. Харин хүний нөөцийн захиалагч байгууллагуудын үйл ажиллагаа Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, салбарын эрх зүйн баримт бичгээр зохицуулагдаж байна.

Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа агентлагуудын удирдлагыг Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18³ дугаар зүйлд заасны дагуу Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газар 6 жилийн

⁴ https://online.zakon.kz/Document/?doc_id=30914968#pos=1;-65

⁵ Б.Бат-Эрдэнэ, Ж.Эрдэнэбулган. Дээд боловсролын засаглал эрх зүйн асуудал, шийдэл.

хугацаагаар томилж, чөлөөлдөг бөгөөд Дотоод хэргийн их сургуулийн хувьд статусаас хамааран нарийвчилсан зохицуулалт одоогоор байхгүй байна. Дотоод хэргийн их сургуулийн хувьд батлагдсан бүтэц, орон тооны дээд хязгаарыг бусад төрийн зарим чиг үүрэг бүхий байгууллагатай харьцуулбал хамрах хүрээ их, алба хаагчийн орон тооны дээд хязгаараас илүү байгаагаас үзвэл төрийн тусгай чиг үүрэг бүхий алба хаагч, хүний нөөцийг бэлтгэн гаргадаг онцлогыг харгалзан үзэж цаашид тус их сургууль нь бие даасан эрх зүйн зохицуулалттай байж болох зайлшгүй хэрэгцээ, шаардлага үүссэн байж болох талтай.

Өөрөөр хэлбэл Дотоод хэргийн их сургуулийг Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болгох хэрэгцээ, шаардлага бий болсон гэж үзэж байна.

Хэрэв Дотоод хэргийн их сургууль нь бие даасан эрх зүйн зохицуулалттай болвол Монгол Улсын Засгийн газар өөрчлөгдөх, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн өөрчлөгдсөн ч Их сургуулийн алба хаагчид нь Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрх зүйн баталгаагаар хангагдана. Түүнчлэн Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсэгт заасан *“Тухайн байгууллагын чиг үүрэгт хууль тогтоомжоор өөрчлөлт орсноос бусад тохиолдолд энэ хуулийн 23.3-т заасан тусгай шаардлага болон албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулахыг хориглоно”* гэсэн хууль зохицуулалт үйлчлэх юм.

Дотоод хэргийн их сургуулийн түүхэн замналын хувьд БНМАУ-ын Ардын сайд нарын зөвлөлийн (хуучин нэрээр) 1933 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 8 дугаар тогтоолоор Дотоодыг хамгаалах газрын дунд сургууль байгуулж байжээ. 1934 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр Дотоодыг хамгаалах газрын даргын 687 дугаар тушаалаар сургуулийн захирлыг томилон орон тоог баталсанаар “Төв сургууль” байгуулагдсан түүхтэй бөгөөд өнөөдрийг хүртлэх хугацаанд нийт 12 удаа өөрчлөн зохион байгуулагдсан⁶.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 229 дүгээр тогтоолоор Хууль зүй, дотоод хэрэг, тагнуулын салбарын боловсон хүчин бэлтгэх, давтан сургах тогтолцоог боловсронгуй болгох, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын уялдааг сайжруулах зорилгоор Цагдаагийн академи, Үндэсний

⁶ Дотоод хэргийн их сургуулийн вэб сайтаас <http://www.leu.gov.mn/page/853.shtml?sel=1584&subsel=1606>

тагнуулын академи, Хилийн цэргийн дээд сургуулийг нэгтгэн Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяанд Дотоод хэргийн их сургуулийг байгуулж байсан⁷.

2012 оноос хууль зүйн салбарын шинэчлэлийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 87 дугаар тогтоолоор Дотоод хэргийн их сургуулийг Хууль сахиулахын их сургууль болгон өөрчлөн зохион байгуулсан⁸.

Гэтэл Монгол Улсын Их Хурлын 2016 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 26 дугаар тогтоолоор Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 53 дугаар зүйлд заасан журмын дагуу Улсын Их Хурлын эцсийн найруулгатай танилцах, ёсчлох, Монгол Улсын Ерөнхийлөгчид илгээх, “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд хэвлэн нийтлэх ажиллагаанууд хийгдээгүй үндэслэлээр Хууль сахиулах ажиллагааны тухай хууль болон бусад хуулиудыг хууль санаачлагчид нь буцаасан байдаг⁹.

Дээрх хууль нь батлагдаагүй гэх үндэслэлээр Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 152 дугаар тогтоолоор Хууль сахиулахын их сургуулийг Дотоод хэргийн их сургууль болгон өөрчлөн зохион байгуулсан бөгөөд тус Их сургуулийн дүрэм, бүтэц, орон тооны хязгаарыг баталж мөрдүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн Сайдад даалгасан¹⁰.

Дээр дурдсан Монгол Улсын Засгийн газраас гаргасан эрх зүйн актуудыг судалж үзвэл Монгол Улсын Засгийн газар өөрчлөгдөх болгонд тус их сургуулийн хуулийн этгээдийн нэршил өөрчлөгдөх, түүнчлэн Их сургуулийн дүрэм, бүтэц, орон тооны хязгаар, албан хэрэг хөтлөлтөд өөрчлөлт орж, улмаар боловсролын индекст өөрчлөлт орох, сургалтын хөтөлбөрт өөрчлөлт орох, цаашлаад сонсогч, суралцагчдын сурлагын чанарт сөргөөр нөлөөлөхөөр байна гэж үзэж байна. Үүнээс гадна гадаадын их, дээд сургуулиудын хамтын ажиллагааны хүрээнд тухайн сургуулиудаас манай сургуульд хандахад хүртэл тодорхой хэмжээгээр хүндрэл учирдаг жишээ гарсаар байна. Гэтэл гадаадын их, дээд сургуулиудын хуулийн этгээдийн нэрийг ойр ойрхон өөрчлөх тохиолдол төдийлөн ажиглагддаггүй

⁷ Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем <https://www.legalinfo.mn/law/details/2372?lawid=2372>

⁸ Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем <https://www.legalinfo.mn/law/details/8763?lawid=8763>

⁹ Мөн тэнд <https://www.legalinfo.mn/law/details/12099?lawid=12099>

¹⁰ Мөн тэнд <https://www.legalinfo.mn/law/details/14309?lawid=14309>

бөгөөд үйл ажиллагаа, статусын хувьд өргөжиж дээд сургуулиас академи, академаас их сургууль болон өөрчлөгддөг зүй тогтолтой.

Дүгнэлт

1. Сургуулийн нэр өөрчлөгдсөнөөр сургалтын хөтөлбөрийн индекст өөрчлөлт орж үл ойлголцол үүсэх магадлалтай. Жишээ татвал, 2012 онд Дотоод хэргийн их сургуулийн нэрийг Хууль сахиулахын их сургууль болгон өөрчилснөөр "Цагдаа-хууль сахиулах ажил", "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх-хууль сахиулах ажил" гэх сургалтын хөтөлбөрүүдийг батлуулсан байдаг. Мэдээж үзэл бодлын хувьд цагдаагийн байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажиллах мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх нь зөв юм. Гэтэл шилжилтийн хөтөлбөр гэж нэрлэгдсэн хөтөлбөрөөр суралцаж судлах ёстой байсан хичээлээ судалдаггүй, эсхүл бүрэн хамрагдаж чаддаггүй г.м. Түүнчлэн, "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх-хууль сахиулах ажил" мэргэжлээр төгссөн төгсөгчид бусад их дээд сургууль, гадаадын их дээд сургуулийн магистрантурт элсэн суралцах боломжгүй бөгөөд хууль сахиулах гэх мэргэжил нь тухайн сургуулиудын тавигдах шаардлагад тохирдоггүй байдал ажиглагдсаар байна. Гадаад оронд ийм жишиг байгаа эсэхийг судлан үзвэл ОХУ-ын ДХЯ-ны сургуулийн төгсөгчид "Правоохранительная деятельность" буюу "хууль сахиулах" гэх мэргэжлээр төгсдөг хэдий ч үндсэн мэргэжлийн чиглэл нь эрх зүй байдаг онцлогтой байна.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн хэрэгжүүлж байгаа "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх-хууль сахиулах" хөтөлбөрөөр суралцаж төгссөн төгсөгчид захиалагч байгууллагын зохих албан тушаалд ажиллахад ажлын байрны тодорхойлолтод заасан тавигдах шаардлагад нийцдэггүй. Тухайлбал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, нэгжид ажиллах ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгчийн ажлын байрны тодорхойлолтод эрх зүйч байхаар, хорих байгууллагын харуул хамгаалалт, аюулгүй байдлын чиг үүрэг бүхий алба хаагчдын ажлын байрын тодорхойлолтод эрх зүйч байхаар тус тус заасан байдаг. Энэ нь сургалт-практик зөрчилдөхөд хүргэж байна.

3. Сургуулийн нэр өөрчлөгдөх бүрт сургуулийн билэг тэмдэг, гадна талбайд байрлуулах нэр, албан бланк, сонсогч, суралцагчдын дүрэмт хувцасны таних тэмдэг, алба хаагчдын үнэмлэх зэргийг өөрчлөх шаардлага гардаг нь жилийн төсөвт суугаагүй тооцоолоогүй зардлыг гаргаж, санхүү

эдийн засгийн асуудал үүсгэдэг. Түүнчлэн Төсвийн тухай хууль тогтоомжоор тухайн жилийн төсөв хуулиар батлагдах үед хуулийн этгээдийн нэрээр батлагдсан байдаг бөгөөд хуулийн этгээдийн нэр өөрчлөгдсөн үед төсвийн мөнгийг зарцуулахад хүндрэл үүсдэг.

4. Ард иргэдийн дунд төөрөгдөл үүсэхээс гадна чухам аль сургуулийг нэрлээд байгаад төдийлөн ойлголт байдаггүй. Цагдаагийн академи, Хууль сахиулахын их сургууль гэсэн нэрээр ойлгож байдаг. Мөн шинээр элсэгчдийн хувьд элсэх сургуулийн нэр, сургалтын хөтөлбөрийн индекс жил бүр өөрчлөгдсөнөөр төөрөгдөл үүсдэг. Их сургуулийн нэршлийн хувьд сонирхолтой баримт сонирхуулад 2009 онд элсэгчид суралцах хугацаандаа 3 сургуульд суралцсан байдаг. Тухайн үед тус сургуульд элсэхдээ Цагдаагийн академид, суралцах хугацаандаа Дотоод хэргийн их сургуульд харин төгсөхдөө Хууль сахиулахын их сургуулийг төгссөн байх жишээтэй.

5. Дотоод хэргийн их сургуулийн дүрэм, бүтэц, орон тооны хязгаарыг хэт ойр ойрхон өөрчлөх нь давуу талтай гэхээсээ илүүтэйгээр сул тал ихтэй, их сургуулийн үйл ажиллагаанд нь сөргөөр нөлөөлөх, бодлогын хэрэгжилтэд гажуудал гарах, бэлтгэж буй хүний нөөцийн мэдлэг чадварт сөргөөр нөлөөлөх, багшийн ажлын ачаалал, механик ажилбар ихсэх, алба хаагч, багш судлаачдын ажилдаа хандах хандлага, идэвх сулрах нөхцөл үүсдэг гэж үзэж байна.

6. Тус Их сургуулийн захирал нь их сургуулийн багш, алба хаагчдыг томилох, чөлөөлөх эрхтэй хэдий боловч тэдэнд цагдаагийн цол болон цэргийн цол олгох, дүрэмт хувцас олгох эрх олгогдсон эрх зүйн зохицуулалт байхгүй нь учир дутагдалтай байна. Өөрөөр хэлбэл, цол олгуулах, цол бууруулах асуудлыг тухайн төв байгууллагын даргад уламжилж шийдвэрлүүлж байгаа нь эрх зүйн чадамжгүй менежер гэж үзэхээр байна. Түүнчлэн тус их сургуулийн багш, алба хаагчид нь цагдаа, хил, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын байгууллагуудын дүрэмт хувцас, цол хэрэглэж байгаа хэдий ч Цэргийн албаны тухай хууль Цагдаагийн албаны тухай хууль, Монгол Улсын Хилийн тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрх зүйн байдал, нийгэм, эдийн засгийн баталгаагаар хангагдахгүй байгаа нь тухайн багш, алба хаагчдын эрх зүйн байдлыг дордуулж байна.

7. Дотоод хэргийн их сургуулийн дүрмын 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт "Их сургуулийн багш, ажилтан нар нь төрийн тусгай алба хаагч

байна” гэж заасан хэдий ч бусад төрийн тусгай байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдал, нийгэм, эдийн засгийн баталгаатай харилцан адилгүй байгаагаас үүдэн тус их сургуульд ажиллахыг төдийлөн сонирхдоггүй байна. Гэтэл гадаадын улс оронд практик байгууллагад ажиллахаас илүүтэйгээр их, дээд сургуулиудад ажиллах сонирхолтой байдаг байна.

Иймд дээр дурдсан үндэслэл, журмыг судалж үзээд Дотоод хэргийн их сургуулийн эрх зүйн орчин боловсронгуй болгох зорилгоор дараахь саналыг дэвшүүлж байна.

1. Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Дотоод хэргийн их сургуулийн статусыг тодорхой болгож, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болгох;

2. Гадаадын ижил чиг үүрэг бүхий их, дээд сургуулиудын туршлагыг судалж, Дотоод хэргийн их сургуулийн багш, алба хаагчийн эрх зүйн байдал, нийгмийн баталгаа, чиг үүргийг тодорхойлсон бие даасан хуультай болгох. Ийнхүү Дотоод хэргийн их сургууль бие даасан хуультай болсоноороо удирдах алба хаагчийг томилох, чөлөөлөх эрх зүйн зохицуулалт нь тодорхой болохоос гадна багш, алба хаагчдын эрх зүйн болон нийгмийн баталгаа, ажиллах орчин нөхцөл бүрэн хангагдах боломж бүрдэнэ гэж үзэж байна.